



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/56/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Алтай хот	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
2022 он	Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546	Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
	Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488	Цахим хаяг: Sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 50

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07920081

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,803,441.96	244,040,425.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	71,537,083.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	71,537,083.00
3121	Төгрөг	-	71,537,083.00
31211	Төрийн сангийн харилцах	-	71,275,534.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	261,549.00
33	АВЛАГА	-	52,513,800.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	52,513,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,803,441.96	119,989,542.69
351	Түүхий эд материал	9,822,337.62	36,859,344.11
35130	Эм боох материал	9,822,337.62	36,859,344.11
354	Хангамжийн материал	51,981,104.34	83,130,198.58
35410	Бичиг хэргийн материал	1,203,000.00	2,757,500.00
35440	Түлш, шатах тослох материал	5,421,420.00	2,272,480.00
35460	Хүнсний материал	8,870,091.00	6,017,605.00
35470	Бусад хангамжийн материал	36,486,593.34	72,082,613.58
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	453,411,537.41	414,284,241.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	453,411,537.41	414,284,241.69
392	Биет хөрөнгө	441,147,537.41	402,125,241.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	107,077,579.00	106,548,379.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,921,748.88)	(29,300,503.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	43,290,911.00	49,104,355.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,499,910.84)	(25,903,290.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	626,181,527.00	606,339,824.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	(325,195,673.25)	(335,865,381.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,786,438.53	49,666,645.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,951,668.44)	(21,271,870.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,409,993.00	3,730,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,029,909.71)	(922,916.71)
393	Биет бус хөрөнгө	12,264,000.00	12,159,000.00
39301	Программ хангамж	950,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(205,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,614,000.00	11,614,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	515,214,979.37	658,324,667.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	515,214,979.37	658,324,667.38
51	Засгийн газрын хувь оролцоо	515,214,979.37	658,324,667.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	393,815,671.47	393,815,671.47
51101	Өмч: - төрийн	393,815,671.47	393,815,671.47
512	Хуримтлагдсан үр дүн	81,601,291.33	234,792,239.23
51210	Өмнөх үеийн үр дүн	81,601,291.33	91,682,551.22
51220	Тайлант үеийн үр дүн	-	143,109,688.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	39,798,016.57	29,716,756.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	515,214,979.37	658,324,667.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	649,013,675.66	1,014,792,107.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	72,802,619.66	200,899,930.85
120	Нийтлэг татварын бус орлого	72,802,619.66	200,899,930.85
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	72,802,619.66	54,645,058.65

Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	146,254,872.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	576,211,056.00	813,892,177.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	540,153,500.00	597,808,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	540,153,500.00	597,808,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,559,100.00	174,785,417.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	89,100.00	1,189,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,429,000.00	39,911,017.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,000.00	2,500,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	131,185,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	35,586,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	35,586,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,498,456.00	5,711,860.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,498,456.00	5,711,860.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	630,854,614.93	871,443,375.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,854,614.93	871,443,375.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	594,258,062.93	827,885,271.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351,143,650.00	395,192,565.00
210101	Үндсэн цалин	240,989,886.00	262,143,961.00
210102	Нэмэгдэл	74,775,346.00	78,839,940.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,324,000.00	5,115,000.00
210104	Урамшуулал	30,054,418.00	30,434,158.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	18,659,506.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,599,323.00	53,765,748.00
210201	Тэтгэврийн даатгал	31,798,923.00	38,586,745.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,741,050.00	3,848,301.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,949,160.00	3,021,521.00
210204	Ажилгүйдлийн даатгал	737,291.00	755,381.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,372,899.00	7,553,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,163,628.00	29,369,146.00
210301	Гэрэл, цахилгаан	3,299,828.00	3,351,271.00
210302	Түлш, халаалт	23,040,000.00	24,915,000.00
210303	Цэвэр, бохир ус	823,800.00	1,102,875.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,292,561.75	176,794,805.36
210401	Бичиг хэрэг	1,281,100.00	1,412,500.00
210402	Тээвэр, шатахуун	8,610,350.00	16,020,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,620,300.00	1,862,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,300,123.00	149,965,701.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,480,688.75	1,156,059.06
210408	Бараа материал акталсны зардал	-	6,377,824.40
2105	Нормативт зардал	28,991,584.43	52,424,859.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,880,992.43	37,507,273.11
210502	Хоол, хүнс	6,110,592.00	14,858,986.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	58,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,196,100.00	2,641,000.00
210604	Урсгал засвар	2,196,100.00	2,641,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,966,000.00	1,524,320.00
210702	Дотоод албан томилолт	1,966,000.00	1,524,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,295,680.00	1,833,718.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,400.00	768,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	196,900.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,200.00	68,720.00

Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	88,500.00
210807	Газрын төлбөр	58,070.00	81,298.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	118,460.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,221,650.00	718,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,609,535.75	114,339,110.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,842,700.00	3,995,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,766,835.75	110,343,310.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,596,552.00	43,558,104.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,569,000.00	41,385,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,569,000.00	41,385,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,027,552.00	2,173,104.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,027,552.00	2,173,104.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	18,159,060.73	143,348,732.34
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	239,044.33
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	239,044.33
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	18,159,060.73	143,109,688.01

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,201,671.47	64,787,674.34	-179,515,529.83	267,473,815.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-146,322.00	-146,322.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	382,201,671.47	64,787,674.34	-179,661,851.83	267,327,493.98
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	395,804,991.63	395,804,991.63
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,815,671.47	39,798,016.57	81,601,291.33	515,214,979.37
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,815,671.47	39,798,016.57	81,601,291.33	515,214,979.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	10,081,259.89	10,081,259.89
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	393,815,671.47	39,798,016.57	91,682,551.22	525,296,239.27
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-10,081,259.89	00.00	-10,081,259.89
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	143,109,688.01	143,109,688.01
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,815,671.47	29,716,756.68	234,792,239.23	658,324,667.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	576,211,056.00	761,378,377.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	576,211,056.00	761,378,377.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	540,153,500.00	597,808,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	540,153,500.00	597,808,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,559,100.00	122,271,617.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	89,100.00	1,189,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,429,000.00	39,911,017.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,000.00	2,500,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	78,671,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		35,586,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		35,586,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,498,456.00	5,711,860.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,498,456.00	5,711,860.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	538,224,056.00	673,031,294.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538,224,056.00	673,031,294.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	501,627,504.00	629,473,190.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351,143,651.00	395,192,451.00
210101	Үндсэн цалин	240,989,887.00	262,143,961.00
210102	Нэмэгдэл	74,775,346.00	78,839,826.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,324,000.00	5,115,000.00
210104	Урамшуулал	30,054,418.00	30,434,158.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	18,659,506.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,599,322.00	53,765,862.00
210201	Тэтгэврийн даатгал	31,687,539.00	38,705,065.64
210202	Тэтгэмжийн даатгал	3,727,946.00	3,818,748.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,982,358.00	2,537,447.31
210204	Ажилгүйдлийн даатгал	745,588.00	1,209,902.53
210205	Эрүүл мэндийн даатгал	7,455,891.00	7,494,697.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,513,628.00	29,012,896.00
210301	Гэрэл, цахилгаан	3,299,828.00	3,351,271.00
210302	Түлш, халаалт	24,390,000.00	24,390,000.00
210303	Цэвэр, бохир ус	823,800.00	1,271,625.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,176,430.00	46,908,920.00
210401	Бичиг хэрэг	1,380,000.00	2,997,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,631,030.00	13,396,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,620,300.00	1,862,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,066,500.00	7,811,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,478,600.00	20,842,140.00
2105	Нормативт зардал	41,825,793.00	80,497,603.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,828,693.00	59,107,603.00
210502	Хоол, хүнс	9,017,600.00	12,006,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,979,500.00	9,383,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,569,600.00	4,994,000.00

Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,371,000.00	594,000.00
210604	Урсгал засвар	2,198,600.00	4,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,966,000.00	1,524,320.00
210702	Дотоод албан томилолт	1,966,000.00	1,524,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,033,880.00	1,803,718.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,400.00	768,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1.00
210803	Даатгалын үйлчилгээ	196,900.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,200.00	68,720.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	88,500.00
210807	Газрын төлбөр	58,070.00	81,298.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	118,460.00	1.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	959,850.00	688,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,799,200.00	15,773,420.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,799,200.00	15,773,420.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,596,552.00	43,558,104.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,569,000.00	41,385,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,569,000.00	41,385,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,027,552.00	2,173,104.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,027,552.00	2,173,104.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	37,987,000.00	88,347,083.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	37,987,000.00	16,810,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,987,000.00	16,810,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,987,000.00	16,810,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,987,000.00	16,810,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	37,987,000.00	(16,810,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	71,537,083.00
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	71,537,083.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	656,348,500.00	565,658,122.00	90,690,378.00	86%
УРСГАЛ ЗАРДАЛ	656,348,500.00	565,658,122.00	90,690,378.00	86%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	653,348,500.00	562,673,122.00	90,675,378.00	86%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	431,295,700.00	360,081,597.00	71,214,103.00	83%
Үндсэн цалин	249,000,000.00	227,033,107.00	21,966,893.00	91%

Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нэмэгдэл	114,000,000.00	78,839,826.00	35,160,174.00	69%
Унаа хоолны хөнгөлөлт	7,400,000.00	5,115,000.00	2,285,000.00	69%
Урамшуулал	37,795,700.00	30,434,158.00	7,361,542.00	81%
Гэрээт ажлын хөлс	23,100,000.00	18,659,506.00	4,440,494.00	81%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,150,000.00	49,349,348.00	8,800,652.00	85%
Тэтгэврийн даатгал	40,975,000.00	34,288,551.64	6,686,448.36	84%
Тэтгэмжийн даатгал	3,825,000.00	3,818,748.84	6,251.16	100%
ҮОМШӨ-ний даатгал	3,560,000.00	2,537,447.31	1,022,552.69	71%
Ажилгүйдлийн даатгал	890,000.00	1,209,902.53	-319,902.53	136%
Эрүүл мэндийн даатгал	8,900,000.00	7,494,697.68	1,405,302.32	84%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,186,000.00	29,012,896.00	2,173,104.00	93%
Гэрэл, цахилгаан	5,199,000.00	3,351,271.00	1,847,729.00	64%
Түлш, халаалт	24,420,000.00	24,390,000.00	30,000.00	100%
Цэвэр, бохир ус	1,567,000.00	1,271,625.00	295,375.00	81%
Хангамж, бараа материалын зардал	34,579,300.00	28,438,920.00	6,140,380.00	82%
Бичиг хэрэг	3,004,000.00	2,997,000.00	7,000.00	100%
Тээвэр, шатахуун	18,142,100.00	13,246,480.00	4,895,620.00	73%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,054,000.00	1,862,300.00	1,191,700.00	61%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,499,200.00	4,491,000.00	8,200.00	100%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,880,000.00	5,842,140.00	37,860.00	99%
Нормативт зардал	56,584,200.00	56,567,223.00	16,977.00	100%
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,165,000.00	38,164,723.00	277.00	100%
Хоол, хүнс	9,019,200.00	9,019,000.00	200.00	100%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,400,000.00	9,383,500.00	16,500.00	100%
Эд хогшил, урсгал засварын зардал	21,818,400.00	21,804,000.00	14,400.00	100%
Багаж, техник, хэрэгсэл	9,594,400.00	9,594,000.00	400.00	100%
Тавилга	7,824,000.00	7,810,000.00	14,000.00	100%
Урсгал засвар	4,400,000.00	4,400,000.00	0.00	100%
Томилолт, зочны зардал	1,876,000.00	1,242,000.00	634,000.00	66%
Дотоод албан томилолт	1,876,000.00	1,242,000.00	634,000.00	66%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,849,200.00	1,243,718.00	1,605,482.00	44%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,075,200.00	208,000.00	867,200.00	19%
Даатгалын үйлчилгээ	280,000.00	108,900.00	171,100.00	39%
Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	68,720.00	81,280.00	46%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,000.00	88,500.00	51,500.00	63%
Газрын төлбөр	85,000.00	81,298.00	3,702.00	96%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	158,000.00	0.00	158,000.00	0%
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	961,000.00	688,300.00	272,700.00	72%
Бараа үйлчилгээний бусад зардал	15,009,700.00	14,933,420.00	76,280.00	99%
Бараа үйлчилгээний бусад зардал	15,009,700.00	14,933,420.00	76,280.00	99%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	2,985,000.00	15,000.00	100%
Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	2,985,000.00	15,000.00	100%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,985,000.00	15,000.00	100%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	656,348,500.00	639,106,760.00	17,241,740.00	97%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	597,808,900.00	597,808,900.00	0.00	100%
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	597,808,900.00	597,808,900.00	0.00	100%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,586,000.00	35,586,000.00	0.00	100%
Орон нутгийн төсвөөс	35,586,000.00	35,586,000.00	0.00	100%

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,953,600.00	5,711,860.00	17,241,740.00	25%
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,953,600.00	5,711,860.00	17,241,740.00	25%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	71,537,083.00	0	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	122,010,068.0
УРСГАЛ ЗАРДАЛ	-	122,010,068.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	83,610,068.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	35,110,854.00
Үндсэн цалин		35,110,854.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	4,416,514.00
Тэтгэврийн даатгал		4,416,514.00
Хангамж, бараа материалын зардал	-	18,470,000.00
Тээвэр, шатахуун		150,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		3,320,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		15,000,000.00
Нормативт зардал	-	23,930,380.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		20,942,880.00
Хоол, хүнс		2,987,500.00
Томилолт, зочны зардал	-	282,320.00
Дотоод албан томилолт		282,320.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	560,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		560,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	840,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		840,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	38,400,000.00
Бусад урсгал шилжүүлэг	-	38,400,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		38,400,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		122,271,617.0
Нэмэлт санхүүжилтийн орлого		122,271,617.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,189,400.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		39,911,017.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,500,000.00
ЭМД сангийн нэмэлт орлого		78,671,200.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		261,549.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын

талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг мөрдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх замаар үйлчлүүлэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилготой.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд сум дундын эмнэлгээс эрүүл мэндийн төв болон өөрчлөгдсөн байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 630.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 871.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төгрөг сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28 хувиар буюу 143.1 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материалын данс байна.

Авлага дансны үлдэгдэл 52.5 сая төгрөг болж өссөн нь гүйцэтгэлээр санхүүжиж нийгмийн даатгалын хэлтсээс авах авлагатай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 119.9 сая төгрөг болж 58.2 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал, хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 168.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, хандиваар 146.1 сая төгрөгийн хүлээн авч үйл ажиллагаандаа 250.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 119.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 414.3 сая төгрөг болж 39.1 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 16.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 54.6 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тавилга машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой.

Тайлант онд Эрүүл мэндийн газраас 8.9 сая төгрөгийн 3 мотоцикл, 11.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн яамнаас авто машины доторлогоо 0.8 сая төгрөгийн, 32.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, НҮБ сангаас 0.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга шилжүүлж авч оны эцэст 414.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэлгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 658.3 сая төгрөг болж 143.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 56 хувиар буюу 365.8 сая төгрөгөөр өссөн нь санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 234.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 642.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 13.4 сая төгрөгөөр өсгөж, 656.3 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төслөөс батлагдсан төсөв их байгаа нь байгууллагын нэр сум дундын эмнэлгээс эрүүл төв болон өөрчлөгдсөнтэй холбоотой.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 656.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 597.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 35.6 сая төгрөгийн, нийгмийн даатгалын сангаас 22.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 565.6 сая төгрөгийг зарцуулж 71.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 565.6 сая төгрөг буюу 86 хувьтай байгаа нь ажил олгогчоос цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 71.2 сая төгрөгөөр, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 8.8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.2 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 6.1 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 0.6 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.6 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 122.0 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба дээд шатны төсөв захирагчаас 39.9 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 81.2 сая төгрөг, хандиваар 1.2 сая төгрөгийн орлогыг тайлагнаж, 0.3 сая төгрөгийг үлдэгдэлтэй. Нэмэлт санхүүжилтийн орлогыг цалин хөлс, хангамж, бараа материал, томилолт, зочны, бусдаар гүйцэтгүүлэх, нэг удаагийн тэтгэмж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу

тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, и-баримт, татварын тодорхойлолт, худалдан авах ажиллагааг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 834.8 сая төгрөгийн 34 мэдээллийг ил тод байршуулахаас 685.2 сая төгрөгийн 24 мэдээллийг ил тод байршуулж, 149.6 сая төгрөгийн 10 мэдээллийг мэдээлээгүй байсныг залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар тендерт шалгараагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 5.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгах 1 заалт албан шаардлага хүргүүлснээс шийдвэр бүрэн хангагдсан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар илүү цагийн бүртгэлийг тулган баталгаажуулах, авлагын барагдуулалтыг үзэх зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Нэр бүхий 5 компаниас 1.8 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлж, 6 компаниас 1.0 сая төгрөгийн илүү шивснийг засуулсан. Татварын тодорхойлолтын 4.5 сая төгрөгийн зөрүүг аудитын явцад залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Илүү цагийн хөлсийг 0.7 сая төгрөгөөр илүү тооцоолж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 50.2-т "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно" гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Тендерт шалгараагүй иргэн ААНБ-аас 5.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн	4	13.8	2	7.4	1	0.7	1	5.5	0	0